



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон АСБИ ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн саналыг хэлэлцсэний үндсэн дээр 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА  Д.ЛХАГВАСҮРЭН





“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг
сонгох тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Асби” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр

1. Д.Лхагвасүрэн
2. Л.Сүмбанд
3. Ч.Дашцэрэн
4. С.Буман-Эрдэнэ
5. Б.Доржсүрэн
6. С.Бат-Эрдэнэ

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр

1. Э.Буянтогтох
2. Л.Нямдаваа
3. Ц.Хадаа нарыг тус тус сонгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжийг баримтлан, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, 62.1.15 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын 2026 оны төсвийг 900,000 /есөн зуун мянган/ төгрөгөөр тогтоосугай.
2. Төсвийн зардалд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН